МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 07 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн
2026 оны хувь хэмжээг тогтоох тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний нэг сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тус тус тогтоосугай.

2.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 (хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн), 6.1.3 (малчин), 6.1.5-6.1.12 (0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан, бусад иргэн)-т заасан иргэний сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 2 хувь, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тус тус тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Г.ЗАНДАНШАТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Ж.ЧИНБҮРЭН